Монгол Японы эмнэлгийн сувилагчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх нь

Т. Хандсүрэн[1], Х. Алтанцацрал[2], Г.Ганхуяг[2]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
[2]АШУҮИС, Монгол Япон Эмнэлэг
Цахим шуудан: khandsuren.tu@mnums.edu.mn, Утас:80498989

Түлхүүр үг:

Соёл
Үнэлгээ
Чанар
Эрсдэл

Товч утга:

Үндэслэл: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал гэдэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх явцад урьдчилан сэргийлж болохуйц алдаа үйлчлүүлэгчид учрахгүй байхыг хэлнэ. Монгол улсын хэмжээнд эмнэлгээр үйлчлүүлж буй 10 үйлчлүүлэгч тутмын нэг нь эмнэлгээс шалтгаалах халдварт өртдөг байна. МЯЭ-ийн сувилагчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх. **Зорилго:** МЯЭ-ийн сувилагчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх. **Арга, аргачлал:** Бид Монгол Японы эмнэлгийг түшиглэн 2021 оны 12-р сарын 28-наас 2022 оны 3-р сарын 15-ны хооронд 99 сувилагчийг хамруулан олон улсад туршигдсан үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын (PSCSE* Nam Ju Li нарын боловсруулсан асуумж, 2017) асуумжаас үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэгийг үнэлэх 6 асуумжийг ашиглан агшингийн загвараар судалгааг хийсэн. **Үр дүн:** Судалгаанд хамрагдсан нийт 99 сувилагчаас 92% эмэгтэй, 7% эрэгтэй сувилагч хамрагдсан ба дундаж нас 30.19±8.14 байсан ба 69% нь бакалаврын зэрэгтэй байна. Судалгаанд хамрагдагсдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэгийн дундаж үзүүлэлт 3.91±0.47 буюу сайн байна. **Хэлцэмж:** Хаэна Жанг, Нам Жу Ли нарын БНСУ-ын эрдэмтдийн баг 2017 оны 9-р сарын 5-ны өдөр Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чадамж, сувилахуйн боловсролын хэрэгцээ сэдэвт судалгааны өгүүллийг хэвлүүлсэн. Дээрх судалгаанд хамрагдсан 144 сувилагчдын мэдлэгийн түвшин, ур чадварын түвшинтэй харьцуулахад харьцангуй доогуур байсан байна. Харин бидний судалгаагаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэг үнэлгээ сайн байна. **Дүгнэлт:** МЯЭ-ийн сувилагч нарын Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэхэд 3.9±0.5 буюу сайн үнэлгээтэй байгаа нь тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах чухал үзүүлэлт болж байна.

Үндэслэл: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын гэдэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид тохиолдох эрсдэл, алдаа, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах асуудлуудыг багтаасан ойлголт юм[1]. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, чанартай тусламж үйлчилгээ нь байгууллагын соёл болон эмнэлгийн мэргэжилтнүүдээс хамааралтай эрүүл мэндийн тогтолцоо, үйл явцын үндэс суурь болдог[2]. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарч буй таагүй үйл явдлын давтамж, түүнээс урьдчилан сэргийлэлтийн талаар дунд болон буурай хөгжилтэй 26 оронд хийсэн судалгаагаар таагүй үйл явдлын түвшин (сөрөг үйл явдал) 8% байсан байна[3]. Монгол улсын хэмжээнд сувилагч мэргэжилтнээр төгсөгч нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлдэг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг дээдлэн ажилладаг, өөрийн ажилдаа шинэ технологийг ашигладаг, судалгаанд суурилсан тусламжийг аюулгүй үзүүлдэг, мэргэжилт нэгт нөхдөө манлайлагч, багаар хамтран ажиллах чадвар бүхий цогц чадамж эзэмших бөгөөд үйлчлүүлэгчийн

аюулгүй байдлыг хангагч, чанарыг сайжруулагч байна хэмээн тусгасан байна[4]. ЭМ-ийн Сайдын 2019 оны А/566 тушаалаар "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам" батлагдсны дагуу эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаатай холбогдуулан АШУҮИС-ийн Монгол Японы эмнэлгийн сувилагчдын үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх хэрэгцээтэй байгаа тул энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Монгол Япон эмнэлгийн сувилагчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх.

Арга, аргачлал: Бид Монгол Японы эмнэлгийг түшиглэн 2021 оны 12-р сарын 28-наас 2022 оны 3-р сарын 15-ны хооронд 99 сувилагчийг хамруулан олон улсад туршигдсан үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын (PSCSE* Nam Ju Li нарын боловсруулсан асуумж, 2017) асуумжаас 6 асуумжийг ашиглан агшингийн загвараар судалгааг хийсэн. Мэдээллийн боловсруулалтанд нийгмийн судалгааны статистик боловсруулалтын программ (SPSS23)-ийг ашиглан сувилагчдын мэдлэгийг **"**5=маш сайн мэднэ"-ээс "1=огт мэдэхгүй" хүртэлх) үнэлгээгээр үнэлсэн. Интервал үнэлгээг 0-1.66 бол муу 1.67–3.32 бол дунд,3.33–5 бол сайн хэмээн ангилсан. АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын Хорооны хурлаар судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авсан (2021 оны 12 сарын 24-н, дугаар 2021/3-13).

Үр дүн: Судалгаанд Монгол Япон эмнэлгийн сувилагчдыг зорилтот бүлгээр сонгон 99 сувилагчийг хамруулж, хүйс, нас, боловсролын зэргээр нь дараах хүснэгтэнд үзүүлэв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагсдын ерөнхий үзүүлэлт

Ерөнхий үзүүлэлт	Үзүүлэлт	N	Хувь
Хүйс	Эрэгтэй	7	7
	Эмэгтэй	**92**	**93**
Нас	20-29 нас	53	53.5
	30-39 нас	30	26.2
	40-49 нас	12	16.1
	50с дээш нас	4	4.04
Боловсрол	Дипломын	24	24
	Бакалаврын	68	69
	Магистрын	7	7

Судалгаанд хамрагдсан сувилагч нарын 92% эмэгтэй, 7% эрэгтэй сувилагч хамрагдсан ба дундаж нас 30.19±8.14 байсан ба 69% нь бакалаврын зэрэгтэй байсан байна.

Судалгаанд хамрагдсан сувилагчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг асуумж тус бүрээр үнэлсэн (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн асуумж

Мэдлэгийн асуулт	Дундаж, стандарт хазайлт	Үнэлгээ
Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг мэднэ	4.18± 0.71	Сайн
Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх бие махбодийн болон сэтгэлзүйн байдал зэрэг хүний хүчин зүйлсийг мэднэ.	4.01± 0.68	Сайн
Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой алдаа, эрсдэл болон аюулыг ялгаж мэднэ.	4.03± 0.48	Сайн
Багийн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын удирдлагын хэвтээ болон босоо тогтолцооны шууд нөлөөллийн талаар мэднэ	3.34± 0.88	Сайн
Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд техник технологийн, мэдээ мэдээллийн давуу болон хязгаарлагдмал нөлөөллийг мэднэ.	3.95± 0.77	Сайн
Алдаанд дүн шинжилгээ хийх үйл явц, гол шалтгааныг тодорхойлж мэднэ.	3.92± 0.57	Сайн
Бүлгийн нийлбэр	**3.91± 0.47**	**Сайн**

Судалгаанд хамрагдагсдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэгийн дундаж үзүүлэлт 3.91±0.47 буюу сайн байна.

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэгийг үнэлсэн 6 асуумжийн дундаж үзүүлэлтийг тасаг нэгжээр нь бүлэглэн гаргасан (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэгийн дундаж үзүүлэлт

Ажиллаж буй Тасаг	0-1.66 (муу)	1.67-3.32 (дунд)	3.33-5 (сайн)	Нийт
ХЭТ1	-	-	16 (16%)	16 (16%)
ХЭТ2	-	-	10 (10%)	10 (10%)
ХЭТ3	-	-	15 (15%)	15 (15%)
Эрчимт эмчилгээ	-	-	7 (7%)	7 (7%)
ЯТТ	-	1 (1%)	10 (10%)	11 (11%)
Амбулатори	-	2 (2%)	22 (23%)	24 (25%)
УДА	-	-	5 (5%)	5 (5%)
Мэс засал	-	1 (1%)	10 (10%)	11 (11%)
Нийт	-	4 (4%)	95 (96%)	99 (100%)

Монгол Япон эмнэлгийн сувилагчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын соёлын талаарх мэдлэгийг тасгаар нь авч үзвэл хэвтэн эмчлүүлэх тасаг-1 3.50-4.67 сайн үнэлгээтэй, хэвтэн эмчлүүлэх тасаг-2 3.50-4.67 буюу сайн үнэлгээтэй, хэвтэн

эмчлүүлэх тасаг-3 3.33-4.33 буюу сайн үнэлгээтэй, Эрчимт эмчилгээний тасаг 3.33-4.33 буюу сайн үнэлгээтэй, Яаралтай тусламжийн тасаг 3.0-5.0 буюу сайнүнэлгээтэй амбулатори 2.83-5.0 буюу сайн үнэлгээтэй, үйлчлүүлэгчийг дэмжих алба 3.67-4.67 буюу сайн үнэлгээтэй, Мэс заслын тасаг 2.50-4.17 буюу сайн үнэлгээтэй байна.

Хэлцэмж: Бид Монгол Япон эмнэлгийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын сувилагч нарын мэдлэгийг судалснаа бусад судлаачдын судалгаатай харьцуулан үзэв.

Хаэна Жанг, Нам Жу Ли нарын БНСУ-ын эрдэмтдийн баг 2017 оны 9-р сарын 5-ны өдөр Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чадамж, сувилахуйн боловсролын хэрэгцээ сэдэвт судалгааны өгүүллийг хэвлүүлсэн.

Дээрх судалгаанд хамрагдсан 144 сувилагчдын мэдлэгийн түвшин, ур чадварын түвшинтэй харьцуулахад харьцангуй доогуур байсан байна. Сургуулийн эмнэлэг дэх дадлагын багш, сувилахуйн зөвлөхүүдийн ур чадварыг харьцуулсан хоёр бүлгийн мэдлэгийн дундаж үнэлгээ хамгийн их ялгаатай байсан байна. Эмнэлгийн дадлагын багш нарын мэдлэгийн түвшин сургуулийн багш нарынхаас өндөр байсан. Иймд судалгаандаа аюулгүй байдлын судалгааны БНСУ-д хийгдсэн хувилбарыг ашиглан үндэстний онцлогыг харгалзан үзэж энэхүү судалгааг хийсэн[5].

Лупей Ян нарын БНХАУ-ын эрдэмтдийн баг 2021 оны 1-р сард үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үнэлгээ, дүн шинжилгээ сэдэвт судалгаа хэвлүүлжээ. Судалгаанд оролцогчид аюулгүй байдлын сургалтанд 51.66%, багийн сургалтанд 44.57% хамрагдсан байна. PSCNES-ийн хувьд эмнэлзүйн дадлага нь хамгийн өндөр дундаж утга 4.05±0.53, аюулгүй байдлын эрсдлийн удирдлагын дундаж утга 4.02±0.48, нотолгоонд үндэслэсэн сувилахуйн дадлагын дундаж утга 3.92±0.55, чанарыг тасралтгүй сайжруулалтын дундаж утга 3.91±0.56, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээний дундаж утга 3.80±0.56 байсан[6]. Энэхүү судалгаа нь бидний судалгаанд хэрэгцээтэй үйчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар судалсан бидний судалгаатай нийцэж байна.

Сон Ми Чо нарын БНСУ-ын эрдэмтдийн баг үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх хандлага, ур чадвар, мэдлэгийн хоорондын хамаарлыг судалжээ. Судалгааг Сөүл хотын их сургуулийн эмнэлэгт ажилладаг 343 сувилагчийг хамруулсан байна. Уг судалгааны дүгнэлтээр сувилахуйн албанд багаар ажиллах, манлайлал, тасралтгүй сургалт явуулж байгаа нь сувилагчдын аюулгүй байдлын чадамжид нөлөөлсөн гол хүчин зүйл байсан боловч эдгээр хүчин зүйлүүдийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын хандлага, ур чадвар, мэдлэгтэй сувилагчдын хоорондын хамаарал харилцан адилгүй байв. Энэхүү судалгаа нь бидний судалгаанд нэн хэрэгцээтэй мэдлэгийн хамаарлыг судалсан нь харагдаж байна[7].

Дүгнэлт: Монгол Япон эмнэлгийн сувилагч нарын Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэхэд 3.9±0.5 буюу сайн үнэлгээтэй байгаа нь тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах чухал үзүүлэлт болж байна.

Талархал: Судалгаа хийх боломжоор хангасан АШУҮИС-ийн МЯЭ-ийн Захиргаа, сувилахуйн албаны хамт олон талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Asem N, Sabry HA, Elfar E. Patient safety: knowledge, influence and attitude among physicians: an exploratory study. J Egypt Public Health Assoc. 2019; 94:22. https://doi.org/10.1186/s42506-019-0022- 9 PMID: 32813209*
2. *Hughes RG, editor. Patient Safety and Quality: An Evidence-Based Handbook for Nurses. Rockville (MD): Agency for Healthcare Research and Quality (US); 2008. http://www.ncbi.nlm.nih.gov/books/ NBK2651/. Accessed 11 Feb 2021*
3. *https:/www.healthcatalyst.com/*
4. *АШУҮИС. Мэргэжилтний цогц чадамж, Сувилагч мэргэжилтний цогц чадамж. 2016.*
5. *Haena Jang, Nam-Ju Lee. Patient safety competency and educational needs of nursing educators in South Korea.*
6. *Lupei Yan, [Lili Yao], [Yuerong Li], et al. Assessment and analysis of patient safety competency of Chinese nurses with associate degrees: A cross-sectional study. Nurs Open. **2021 Jan; 8(1): 395–403.***
7. *Seung Eun Lee, MeenHye Lee, Anya Bostian Peters, Seok Hyun Gwon. Assessment of Patient Safety and Cultural Competencies among Senior Baccalaureate Nursing Students. Int J Environ Res Public Health. 2020 Jun; 17(12): 4225. Published online 2020 Jun 13. doi: 10.3390/ijerph17124225*

Safety of nurse clients evaluate knowledge of Mongolian Japanese hospital

Khandsuren T[1], Altantsatsral KH[2], Gankhuyag G[2]
[1]School of Nursing, MNUMS
[2]Mongolian-Japanese Hospital of MNUMS
E-mail: khandsuren.tu@mnums.edu.mn, Tel: 80498989

Background: Client safety means that the client does not make preventable mistakes in the provision of health care. One in 10 hospitalized patients in Mongolia suffers from a hospital acquired infection. Assess Mongolian-Japanese Hospital nurses knowledge of client safety.
Aim: Assess the safety knowledge of Mongolian-Japanese Hospital nurses.
Materials and Methods: Based on the Mongolia-Japan Hospital, we surveyed 99 nurses between December 28, 2021 and March 15, 2022, using an internationally tested client safety questionnaire (PSCSE * Nam Ju Li et al., 2017). The survey was conducted using a snapshot model using 6 assessment questionnaires.
Result: Of the 99 nurses surveyed, 92% were female and 7% were male, with an average age of 30.19±8.14, and 69% had a bachelor degree. The average customer safety knowledge of the respondents was 3.91±0.47 or good.
Conclusion: A score of 3.9±0.5 or a good score to assess client knowledge of Mongolian and Japanese Hospital nurse client safety is an important indicator of care safety.

Keywords: culture, quality, risk, assessment